



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 1/218

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е” заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн 4 том туулийн нэг, Монголын эртний утга зохиолын гурван оргилын нэг болох “Жангар” туулийг ард иргэдэд сурталчлан таниулах, залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор Монголын театр урлагийн байгууллагаас анхлан “Дуулалт жүжиг” болгон тайзнаа амилуулж, нутгийн зон олондоо толилуулсан Хөгжимт драмын театрын дуу шумны техникч Т.Одбаяр, бүжиг дэглээч багш С.Алтанхуяг нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Т.Одбаяр, С.Алтанхуяг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг аймгийн Хөгжимт драмын театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Ариунжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ